

Монгол улсын сангийн яам,
НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн
суурин төлөөлөгчийн газрын
“Сэтгэх хүч” төсөл

**Ажлын таван өдөрт шилжих
боломжийг
судалсан тухай дүгнэлт, санал**

МОН-97/131

Төслийн үндэсний зөвлөх. Д.д

..... Д.Зандангарав
(Зах зээлийн сургалт,
зөвлөлгөөний “Ундраа”
төвийн захирал)

Улаанбаатар хот,
1997 оны 9-10-р сар

Д.Занданшарав, д/д
Эдийн засаг, нийгмийн өсөлтөд
стратегийн дэмжлэг үзүүлэх
“Сэтгэх хүч” төслийн үндэсний
зөвлөх

АЖЛЫН ТАВАН ӨДӨРТ ШИЛЖИХ БОЛОМЖИЙГ СУДАЛСАН ТУХАЙ

(ДҮГНЭЛТ, САНАЛ)

Ажлын таван өдөрт шилжих нь нийгэм, эдийн засаг, хүмүүнлэгийн өргөн цар хүрээтэй зорилт юм.

Асуудлын мөн чанарыг тодорхойлох, бодит нөхцөл байдлыг илрүүлэх зорилгоор “Сэтгэх хүч” төслийн ажлын хэсэг энэ талаар өмнө судлагдаж боловсрогдсон материалууд хийгээд Засгийн газар, УИХ дээр хэлэлцэж гаргасан шийдвэр, дүгнэлттэй нарийвчлан танилцаж, эдийн засгийн макро түвшний холбогдох үзүүлэлтийг шаардагдах хэмжээгээр судлан төр, аж ахуйн 33 байгууллага, төв орон нутгийн захиргаа, иргэдийн төлөөлөгчдийн хурал, шүүх, сэргийлэхийн байгууллагын 95 ажилтан, нийт 433 иргэнийг хамруулан санал асуулга явуулж судалгаа хийв.

Ер нь долоо хоногийн ажлын өдөр, цагийг хорогдуулах асуудал нь аливаа нэгэн улс үндэстний төдийгүй дэлхий нийтийн чанартай түгээмэл зорилт болон шийдвэрлэгдэж ирсэн байна.

Дэлхий нийтийн хөдөлмөрийн харилцааг засгийн газар, үйлдвэрийн эзэд, үйлдвэрчний байгууллага (ажиллагсад)-ын эрх ашиг, сонирхолд нийцүүлэн зөвшин хэлэлцэх зорилгоор 1919 онд байгуулагдсан Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ) анхны ерөнхий бага хурлаараа “Аж үйлдвэр дэх ажлын цаг”-ийн асуудлыг хэлэлцэн “Аж үйлдвэрийн ажлын цагийг өдөрт 8 цаг, долоо хоногт 48 цаг болгож хорогдуулах тухай” конвенц гаргаж, улмаар 1930-аад оны эхнээс худалдаа, нийтийн хоол, зочид буудал, ресторан, эмнэлэг зэрэг үйлчилгээний байгууллагуудыг, 1936 оноос олон нийтийн байгууллагуудыг долоо хоногийн ажлын 48 цагт шилжүүлэхийн хамт илүү цагийг хязгаарлах, уг цагийн хөлсний тарифыг 1/4-ээр өсгөх тухай асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэн, долоо хоногийн ажлын таван өдөр, 40 цагт шилжих конвенцийг бүр 1935 онд гаргасан боловч 22 жилийн дараа 1957 онд батламжлагджээ.

Ажлын цагийг хорогдуулах тухай конвенц улс орнуудын практикт ийнхүү зуунга, удаан хэрэгжсэн нь:

Нэгд-үндэсний нийт бүтээгдэхүүн нь зөвхөн үйлдвэр, пүүс, байгууллагын зохион байгуулалттай ажлын цагт төдийгүй чөлөөт цагт үргэлжлэн бүтээгдэж, арвижиж байдаг ач холбогдол өгөөгүй.

Хоёрт-чөлөөт цаг нь ажлын цагийн үргэлжлэл бөгөөд хөдөлмөрийн бүтээмж, чанарт нөлөөлдгийг хүлээн зөвшөөрөөгүй.

Гуравт-үйлдвэрлэл, үйлчилгээг ажлын цагийн өсөлт (эрчимгүй арга)-оор хангах эрмэлзлээс төдийлөн татгалзаж чадаагүй.

Дөрөвт-хөдөлмөрийн харилцаа, ялангуяа түүний шинжлэх ухааны зохион байгуулалтын орчин үеийн арга зүй боловсрогдоогүй байсан зэрэгтэй холбоотой.

Энэ хандлага үндсэндээ өөрчлөгдсөний дүнд 1960-аад оны эхэн гэхэд дэлхийн улс орнуудад долоо хоногийн ажлын 6 өдөртэй, 46-48 цагийн горим давамгайлах болжээ. 1970-аад оны эхэн үеэс дэлхийн улс орнууд долоо хоногийн ажлын өдрийг 46 биш, 40 түүнээс ч бага болгох чиглэлээр чухал алхмууд хийжээ.

1989 оны байдлаар европын аж үйлдвэржсэн 14 орноос хамгийн олон цагтай нь Португали (44 цаг) хамгийн бага нь Норвеги, Франц (33,36 цаг) байв (“Цаг үе өөрчлөгдөж байна” номоос авав. ОУХБ, Женев, 1994). Харин энэ үед Япон, Сингапур, Гонконг, Өмнөд Солонгос зэрэг Азийн өндөр хөгжилтэй болон түргэн хөгжиж байгаа зарим орны 7 хоногийн ажлын цагийн үргэлжлэх хугацаа 45-50 цаг, ажилгүйдлийн хувь хэмжээ барууны орнуудынхаас 1,5-2 дахин бага байв. Гэхдээ эдгээр орны хүн амын статистик бүртгэлийн бүтцийг судалж үзэхэд тэнд гэрээрээ болон хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа хөдөлмөрийн зах зээлд албан ёсоор бүртгэгдээгүй хүмүүсийг хамруулан авч үздэг байна.

Хуучин “социалист” гэгдэж байсан Зүүн европийн бүх орон 1970-аад оны эхээр бараг нэгэн зэрэг ажлын 5 өдөртэй 7 хоногт шилжиж түүнийгээ социализмын “давуу тал” хэмээн сурталчилж байв. Манай агуу их хоёр хөрш ЗХУ (хуучин нэрээр) 1971 оноос, БНХАУ 1995 оны 5-р сарын нэгнээс ажлын 5 өдөртэй 7 хоногт орон даяар шилжжээ. Хөгжлийн ерөнхий түвшнээр манайхтай ойролцоо БН Кампучи улс 1996 оны 5-р сард төсвөөс цалинждаг бүх хүний (багш нараас бусад) 7 хоногийн ажлын өдрийн тоог 5 болгон хорогдуулжээ. Малайз улс 1980-аад оны эхээр ажлын 5 өдөртэй 7 хоногт шилжжээ.

Орчин үед чөлөөт цагийн үнэ цэнэ ихээхэн өсөж байгаагийн зэрэгцээ харилцаа холбоо компьютерийн техникийг ашиглан алсаас ажиллах хэлбэр их дэлгэрч байна.

АНУ-д 1992 оноос хойш төлө-ажлын байрны ТОО жил тутам 15 хувиар өсөж байна. ОУХБ-ын мэдээгээр дэлхийд 100 сая хүн “дөрвөн хананы”-хаа дундаас гарахгүй ажиллаж, амьдарч, бүтээн туурвиж байгаа ажээ. Эдгээрээс үзэхэд бидний амьдарч байгаа ХХ зуун нь ажлын 5 өдөр, 40 цагт дэлхий нийтээрээ шилжиж улмаар ажлын өдрийн тоог 4 болгон хорогдуулах ажил бодит зүйл болох эрэнг авчирч буй нь тодорхой байна.

Төслийн хүрээнд манай орны иргэд, байгууллагын дунд явуулсан санал асуулгын дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 68,8 хувь нь, түүний дотор жирийн иргэдийн 71,2 хувь нь, төрийн захиргааны ажилтнуудын 57,7 хувь нь, аж ахуйн байгууллагын 34,6 хувь нь ажлын таван өдөрт шилжихийг дэмжив. Харин аж ахуйн байгууллагын 41,4 хувь нь тээнэгэлзэж, зөвхөн 24,1 хувь нь татгалзсан байна. Ажлын 5 өдөрт шилжсэнээр бий болох чөлөөт цагийг жирийн иргэдийн 11,1 хувь нь хувиараа хөдөлмөрлөх, туслах аж ахуй хөгжүүлэхэд зарцуулна гэж хариулжээ. Одоогийн байдлаар нийслэл хотын иргэдийн гэр бүлийн орлогын 15,5 хувь нь хувийн туслах аж ахуйгаас, 12,5 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлснээс орж байна. Энэ нь нийгмийн баялаг зөвхөн зохион байгуулалттай ажлын цагийн хүрээнд төдийгүй чөлөөт цагт бүтээгдэж байдгийн илрэл юм. Гэхдээ судалгаанд хамрагдсан иргэдийн 45,9 хувь нь амьдралын хэвийн нөхцөл бүрдүүлэхэд зориулна гэж үзсэн нь уг зорилт эдийн засгийн гэхээсээ илүү нийгмийн чухал ач холбогдолтой болохыг харуулж байна.

Ажлын таван өдөрт шилжсэнээр тээвэр, харилцаа холбоо, эрчим хүч, орон сууц, усан хангамж, радио телевиз, эрүүл мэнд гэх зэрэг дэд бүтцийн шинжтэй салбарын хүрээнд шинээр 6,2 мянган ажлын байр бий болж, албан ёсны бүртгэлээрх ажилгүйдлийг 10 орчим хувиар бууруулах боломжийг бүрдүүлэхээр байна. Тэдгээрт 1,7 тэрбум гаруй төгрөгийн цалингийн нэмэлт сан шаардагдах тооцоо гарав.

Энэ оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр төрийн захиргааны болон төсөвт 6073 байгууллагад 141,2 мянган хүн (удирдах ажилтан 9,5 мянга, гүйцэтгэх ажилтан 94,5 мянга, үйлчилгээний ажилтан, ажилчин 37,2 мянга) ажиллаж байгаа бөгөөд ажлын таван өдөрт шилжсэнээр эдгээр хүмүүсийн цалин хөлс буурахгүй харин цалингийн одоогийнхоос бага зэрэг өсөх боловч байгууллагын ажиллах нөхцөлтэй холбоотой цахилгаан, дулаан, түлш, эрчим хүч, шуудан холбоо, бичиг хэргийн зэрэг тогтмол зардал 2,5 тэрбум төгрөгөөр хэмнэгдэх боломж бий.

Ажлын таван өдөрт шилжих асуудлыг төрийн захиргааны бүтцийн өөрчлөлт, хөдөлмөрийн хөлс, урамшууллын шинэлэг арга хэмжээгээр баталгаажуулж чадвал хэмнэлтийн үр дүн үүнээс ч дорвитой байж болохоор байна.

Гол нь төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагуудын ажил, үүргийн хуваарилалт, эрх мэдлийн тэнцлийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх, ажлын арга барил, технологийг боловсронгуй болгох чиглэлээр бүтцийн өөрчлөлт хийх нь ашигтай.

Удирдлагын төвлөрлийг сааруулахтай холбогдуулан Баянхонгор, Дундговь, Өвөрхангай, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл аймаг, тэдгээрийн 24 сумыг хамруулан өөрийн оролцооны аргаар явуулсан судалгаанаас үзэхэд төрийн үйлчилгээний байгууллагууд нийт 820 орчим ажил, үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд тэдгээр нь удирдлагын янз бүрийн түвшинд давхцал ихтэй байна. Ажил, үүргийн хуваарилалт оновчтой бишээс төрийн байгууллагын 20 хувь нь бусад байгууллагын ажлыг гүйцэтгэж, 23,3 хувь нь бусдаар ажлаа гүйцэтгүүлж байгаа бөгөөд төрийн үйлчилгээний байгууллагуудын нийт ажил, үүргийн 26,7 хувийг зохих чадамж бүхий олон нийтийн болон судалгаа, зөвлөлгөөний байгууллага, үйлчилгээний зарим байгууллагад хариуцлагын хамт шилжүүлэх боломж байна. Зарим ажлыг төрийн байгууллагууд гэрээгээр гүйцэтгүүлж болох юм.

Өмнө дурдсан аж ахуйн нэгжүүдэд хийсэн судалгааны дүнгээс үзэхэд ажлын өдрийн үргэлжлэлийн 10 хувийг бэлтгэл, төгсгөлийн ажилд, 56,6 хувийг шуурхай буюу үндсэн ажилд, 4 хувийг технологийн завсарлагад, 12,5 хувийг горимлогдож тогтоогддог хувийн хэрэгцээнд, 2 хувийг эмнэлэгт үзүүлэх зэрэг зайлшгүй чөлөөнд зарцуулж, үлдэх 14,9 хувийг сул зогсож байна. Түүний 10,4 хувь нь үйлдвэрлэлээс, 4,5 хувь нь ажиллагсдын буруугаас шалтгаалан гарч байна. Өөрөөр хэлбэл үйлдвэрлэл, хөдөлмөрийнхөө зохион байгуулалтыг өөрчилж орчин үеийн менежментийг хэрэглэж дор хаяж ажлын өдрийн доторх сул зогсолтыг арилгаж чадвал хөдөлмөрийн бүтээмжийг 17,5 хувиар өсгөж, ажлын таван өдөрт шилжсэнээс одоогийн бүтээмжид гарч болзошгүй 15 хувийн бууралтыг өлхнөө нөхөж чадах боломж байгаа нь энэ судалгаанаас харагдаж байна.

Татварын албаны шинэчилсэн мэдээгээр манайд 30.8 мянган аж ахуйн нэгж байгаагаас 71 томоохон байгууллага улсын төсвийн орлогын 90 хувийг бүрдүүлж байна.

Энэ оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр нийт татварын орлогын 72,3 хувийг бүрдүүлдэг аж ахуйн нэгжүүд долоо хоногийн ажлын 5 өдрөөр ажиллаж байгаагийн дотор “Эрдэнэт” йлдвэр, ИАТУГ, “Говь” комбинат, АПУ, Монгол савхи, Алтан тариа, Монгол нэхмэл, Сор, Материалимпэкс, Нэхээсгүй эдлэл, Дарханы нэхий, Гурил тэжээл хувьцаат компани, Монгол экспорт УҮГ, Монросцветмет, Мончехметалл нэгдэл зэрэг томоохон аж ахуйн нэгжүүд орж байна.

Ийнхүү ажлын таван өдөрт шилжих нь зорилт төдий зүйл биш, харин амьдралд бодитой хэрэгжиж буй үйл явц нэгэнт болжээ.

Гэгээрлийн яамнаас бүх шатны сургуулийг сургалтын 5 өдөрт шилжүүлэх ажлыг 1997 оны 2-р сараас хэрэгжүүлж эхэлснээр нийт сургуулийн 66 хувьд нь зардал хэмнэгдсэн буюу хэвийн хэмжээнд үлдэж, зөвхөн 4,9 хувьд нь нэмэлт хөрөнгө шаардагджээ.

Харин хөдөөгийн сургуулиудад сурагчдыг хоёр өдөр дараалуулан амраах нь дотуур байрны хүүхдүүдэд урьдахаас нь харьцангуй удаан хугацаанд эзэнгүйтэх, хийх зүйлгүй гиюүрэх, гэр орондоо зайчлан очиж хичээлээс хожигдож ирэх сөрөг нөлөөлөл байгааг харгалзан долоо хоногт заавал 5 өдөр гэхгүйгээр хуучин горимоор нь ажиллуулж, харин уламжлалт цагаан сараас эхлэн мал төллөлтийн үеэр амраах замаар зохицуулж болох юм.

Ер нь хөдөө аж ахуйн ажлын үе нь үйлдвэрлэлийн үетэйгээ давхцдаггүйгээс мал төллөлт, хаврын тариалалт, намрын ургац хураалтаар ажлын өдрийн үргэлжлэлийг зайлшгүй уртасгах шаардлага үүсдэг. Ийм шаардлага байгаль цаг уурын болон уул-геологийн нөхцлөөс хамааран бусад салбарт ч гардаг. Түүнийг илүү цаг гэхгүйгээр өнөөг хүртэл технологийн картаар зохицуулж иржээ.

Үүнээс үзэхэд ажлын таван өдөрт шилжих нь салбаруудын онцлогоос хамааран хөдөлмөр, амралтын тус тусын горимоор уян зохицуулагдах ёстой бөгөөд гол нь тухайн жилд ажиллах нийт цаг нь улирлуудаар аль болох ойролцоо байхаар хуваарилагдсан байх нь ашигтай гэж үзэж байна. Малчдын тухайд ажил, амралтаа мал аж ахуйг эрхэлж ирсэн уламжлалт аргаараа зохицуулсаар явах нь тодорхой.

ОУХБ-ын конвенцид ч өрх гэрээрээ аж ахуй эрхэлж буй хүмүүсийн ажил, амралтыг зохицуулах асуудлыг авч үзэхгүй байгаа нь дээрх онцлогуудтай холбоотой.

Харин бүх нийтээр ажлын таван өдөрт шилжих нь өмчийн аль ч хэлбэрт ажиллагсдын хөдөлмөрийг төрөөс иргэдийнхээ эрх ашгийн үүднээс зохицуулах нийтлэг шаардлагас урган гарч байна.

Үүнтэй уялдуулан ажлын таван өдөрт шилжих талаар УИХ-аас тусгайлан хууль гаргахын хамт дагаж мөрдөж байгаа хөдөлмөрийн болон холбогдох бусад хууль тогтоомжид өөрчлөлт оруулах тухайлбал, Хөдөлмөрийн хуулийн 4-р бүлгийн 25-р зүйлийн 1-р заалтыг “Долоо хоногийн ажлын хэвийн үргэлжлэл нь 5 өдөр, 40 цагаас илүүгүй байна” гэсэн засвар оруулах хэрэгтэй бол но.

Харин ээлжийн амралтыг хорогдуулах асуудлыг зохих түвшинд шийдвэрлэх шаардлагатай. Хөдөлмөр зохион байгуулалт, физиологийн ухааны талаас авч үзвэл хүмүүсийг урт хугацааны турш амралт багатай ажиллуулж туйлдуулаад алдагдсан эрч хүчийг нь нөхөх гэж удаан амраах биш, богино цагт эрчимтэй ажиллуулж алжаалыг нь тухай бүр тайлж

зарцуулсан энергийг дор бүр нь сэлбэж байх нь илүү ач холбогдолтой гэж үздэг. Хэт удаан амрах нь амрах биш, “ядраах” байдалд оруулдгийг бодолцож ажлын таван өдөрт шилжсэн тохиолдолд ээлжийн амралтыг дэлхийн ихэнх орны жишгээр богиносгох арга хэмжээ авах нь зохимжтой бөгөөд энэ талаар үйлдвэрчний болон бусад зарим байгууллагатай тохиролцож зохих зөвшилд хүрэх нь чухал юм.

Ажлын таван өдөрт шилжих нь эерэг талтай ч бас архидах, сэлгүүцэх, танхайрах зэргээр энэ боломжийг буруу ашиглах сөрөг үзэгдэл гарч болохыг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах нь чухал.

Хөдөлмөрийн харилцааг зохицуулахад хууль, тогтоомжоос гадна байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөр, амралтын горим чухал үүрэгтэйг харгалзан тэдгээрийн үндэслэл, агуулгыг шинэ нөхцөлд нийцүүлэн өөрчилж ягштал баримталдаг байх шаардлага тавигдана.

Ажлын таван өдөрт шилжих арга хэмжээг цалинг хэвээр хадгалах замаар хэрэгжүүлэх нь үнэ хөөрөгдөлтөд хүрэхгүй ач холбогдолтой.

Нийт байгууллага, иргэд хуулиа хүлээн авч хэрэгжүүлэхэд бас зохих бэлтгэл, хугацаа хэрэгтэйг харгалзан уг арга хэмжээг 1998 оны хоёрдугаар улирлаас эхлэн хэрэгжүүлж болох юм.

Зарим тооцоо, судалгааны дүнг хавсаргав.

Хавсралт № 1

АЖЛЫН ТАВАН ӨДӨРТ ШИЛЖИХИЙГ ДЭМЖИЖ АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГА, ИРГЭДЭЭС ӨГСӨН САНАЛ

№	Долоо хоногийн ажлын цагийн үргэлжлэлийг багасгах хувилбар	Аж ахуйн байгууллага	Иргэд, бугд	Үүнээс	
				Жирийн иргэд	Төрийн ажилтанууд
1.	Хөдөлмөрийн болон хол-богдох бусад хууль, тог-тоолд өөрчлөлт оруулсны үндсэн дээр бүх нийтээрээ 1998 оноос шууд шилжих (38 %)	40,0	36,9	38,0	23,3
2.	Хууль эрх зүйн орчинг бүр-дүүлж зохих бэлтгэл хан-гасны үндсэн дээр 2000 он хүртэл ээлж дараатай, үе шаттай шилжих (16 %)	12,0	15,9	16,0	12,3
3.	Эхлээд төрийн захиргааны төсөвт байгуулага, үлсын үйлдвэрийн газруудыг шилжүүлж бусад аж ахуйн нэгж, байгууллагыг ойрын 2-3 жилийн дотор зохих бэлтгэлээ хангасны үндсэн дээр багтаж шилжих эрх олгох(15,8 %)	28,0	17,6	15,8	27,4
4.	Эхлээд ажиллаж байгаа тахир, дутуу иргэд, насанд хүрээгүй болон хөдөлмөрийн нас хэтэрсэн ир-гэд, олон хүүхэдтэй	8,0	11,0	11,2	8,2

	өрх толгойлсон эмэгтэйчүүд, ойндоо хүрээгүй хүүхэдтэй эхчүүдийг шилжүүлж бусад ажиллагсдыг ойрын 2-3 жилд багтаан шилжүүлэх (11,2 %)				
5.	Долоо хоногийн ажлын өдрийг сэрүүн, хүйтний улиралд тус бүр 8 цагтай 5 өдрөөр, дулааны улирал (4-р сарын 1-нээс 10-р сарын 1 хүртэл)-д тус бүр 8 цагтай 5,6 цагтай нэг өдөр (хуучин горимоор) тогтоож долоо хоногийн дундаж үргэлжлэл нь (жирийн дунджаар тооцсоноор) 40-41 цат байхаар бодож тогтоох (11,2 %)	8,0	11,0	11,2	8,2
6.	Долоо хоногийн ажлын өдрийн тоог бус харин даваа, мягмар, лхагва, пүрэв, баасан гаригт тус бүр 7 цат, бямба гаригт 6 цагаар нийт 40 цат ажиллахаар зөвхөн ажлын цагийг хорогдуулах(7,8 %)	4,0	7,6	7,8	5,5
	Дүн	100%	100%	100%	100%

Хавсралт № 2

**АЖЛЫН ТАВАН ӨДӨРТ ШИЛЖИХИЙН ЭЭРЭГ ТАЛ,
ХАРИУЛТЫН ЭЗЛЭХ ХУВИАР**

	Эерэг талууд	Аж ахуйн байгуул лагууд	Иргэд, бүгд	Үүнээс		Бүгд
				Жирийн иргэд	Төрийн албан хаагч	
1	Сурах, соёлжих, эрүүл мэн дээ хамгаалах, ач тохитой амьдрах зэрэг нийгмийн ач холбогдолтой нөхцөл, боломж олгоно	32,9%	38,1%	39,5%	37,4%	37,7%
2	Хөдөлмөрийн бүтээмж чанар дээшилнэ	25,6%	19,2%	15,5%	24,1%	20,1%
3	Ажил эрхлэлт сайжирч, ажилгүйдэл багасна	15,0%	12,4%	9,6%	16,3%	12,8%
4	Үнэ, тариф буурч зардал хэмнэгдэнтөсвийн ачаа-лал, татварын дарамт багасна	10,5%	11,8%	16,4%	5,4%	11,6%
5	Орлого нэмэгдэнэ	6,2%	7,3%	9,7%	3,9%	7,1%
6	Зах зээлийн өрсөлдөөн хөгжинэ	3,9%	5,6%	4,6%	7,1%	5,4%
7	Аялал жуулчлал, үйлчил-гээний дэд бүтэц хөгжинэ	5,9%	5,2%	4,7%	5,8%	5,3%
	Дүн	100%	100%	100%	100%	100%

**АЖЛЫН ТАВАН ӨДӨРТ ШИЛЖИХ ҮЕИЙН СӨРӨГ
ТАЛУУД, ХАРИУЛТЫН ЭЗЛЭХ ХУВИАР**

	Сөрөг саналууд	Аж ахуйн байгууллагууд	Иргэд, бүгд	Үүнээс		Бүгд
				Жирийн иргэд	Төрийн албан хаагчид	
1	Хөдөлмөрийн бүтээмж буурна	27,9%	21,7%	23,8%	17,9%	22,8%
2	Байгууллага, иргэдийн орлого буурна	21,8%	18,4%	15,6%	20,5%	19,0%
3	Архидалт, танхайрал, залхуурал ихсэж, аюулгүй байдал алдагдана	16,8%	17,7%	17,2%	18,1%	17,6%
4	Багш нарын ачаалал их-сэж, оюутан, сурагчдын соёл-хүмүүжлийн ажил сулрана	9,7%	11,7%	6,4%	16,1%	11,3%
5	Ард нийтээрээ хүчлэн зүтгэж хямралаас тарах сэтгэл зүй, эх орныхоо хөгжлийн төлөө цат хожих боломж алдагдана	5,0%	8,9%	3,2%	13,5%	8,1%
6	Байгаль, орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл ихсэнэ	6,7%	6,5%	9,0%	4,6%	6,6%
7	Бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ, зардал өснө	5,1%	4,9%	8,3%	2,2%	5,1%
8	Хүн амын ажил, амьдралын хэвшил өөрчлөгдөж түүнийг шинээр төлөвшүүлэхэд багагүй хүч чармайлт шаардагдана	6,7%	3%	3,5%	2,6%	3,7%
9	Бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний чанар буурна	—	4,1%	3,7%	4,5%	3,3%
10	Зээлтэй холбогдон хээл, хахууль, авилгал ихсэнэ	—	1,7%	3,8%	—	1,4%
11	Үнэ, зардал, татвар өссөнтэй холбогдон жижиг аж ахуйнууд олноор дампуурна	—	1,4%	3%	—	1,1%
	Дүн	100%	100%	100%	100%	100%

**АЖЛЫН ТАВАН ӨДӨРТ ШИЛЖСЭНЭЭР НЭМЖ
ШААРДАГДАХ ОРОН ТОО, ЦАЛИНГИЙН САНГИЙН ХЭМЖЭЭ**

№	Салбарын нэр	Шинээр шаардагдах орон тоо	Цалингийн сан (сая. төг)
1.	Төмөр зам	825	396.0
2.	Авто тээвэр	250	90.0
3.	МИАТ	270	194.4

4.	Эрчим хүчний салбар	390	192.7
5.	Нүүрсний уурхайнууд	595	524.8
6.	Харилцаа, холбоо	120	56.0
7.	Орон сууц, ус хангамж	200	49.6
8.	Радио, телевиз	64	29.9
9.	Эрүүл мэнд	3500	188.3
	ДҮН	6214	1721.7

АЖЛЫН ӨДРИЙН ЦАГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН БҮТЭЦ

- | | |
|------------------------------|-------|
| 1. Бэлтгэл төгсгөлийн ажилд | 10% |
| 2. Шуурхай (үндсэн) ажилд | 56.6% |
| 3. Технологийн завсарлага | 4% |
| 4. Хувийн хэрэгцээнд | 12.5% |
| 5. Сул зогсолт | 14.9% |
| Үүнээс: | |
| а) Үйлдвэрлэлээс шалтгаалсан | 10.4% |
| б) Ажилтнаас шалтгаалсан | 4.5% |
| 6. Бусад цаг | |

$$ХБдн = 17,5\% \left(\frac{4,9x + 100x}{100x - 14,9x} \right)$$

$$ХБхш = 15\% \left(\frac{46 + 40}{40} \right) x$$

**АЖЛЫН ТАВАН ӨДӨРТ ШИЛЖИХИЙГ ДЭМЖСЭН,
ТАТГАЛЗСАН БАЙДАЛ**

АЖ АХУЙН БАЙГУУЛЛАГУУДАД

Дэмжсэн 34.5 %
Түдгэлзсэн 41.4%
Татгалзсан 24.1%

ТӨРИЙНЗАХИРГААНЫАЖИЛТНУУД

Дэмжсэн 57.7%
Түдгэлзсэн 34.6%
Татгалзсан 7.7%

ИРГЭД

Дэмжсэн 71.2%
Татгалзсан 57.7%
Дэмжсэн 18.9 %

ЧӨЛӨӨТ ЦАГИЙГ ЮУНД ЗАРЦУУЛАХ ВЭ?

ИРГЭД

- I Хувиараа хөдөлмөр эрхлэхэд
- II Амьдралын хэвийн нөхцөл хангахад
- III Үр хүүхдээ өөрсдөө сурах, соёлжих, эрүүл мэндээ хамгаалах зэрэгт

ТӨРИЙН АЖИЛТНУУД

1. Хувийн бизнес, туслах аж ахуйд
2. Амьдралын хэвийн нөхцөл хангахад
3. Үр хүүхдээ хүмүүжүүлэх, өөрсдөө сурах, соёлжих, эрүүл мэндээ хамгаалах зэрэгт